



МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБОО

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2019



# АГУУЛГА

УДИРДАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

САНХҮҮ

ХАМТЫН АЖИЛЛАГАА

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ

МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА

ДҮГНЭЛТ

## МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.01.26.

Монголын Философийн Холбоо нь 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлынхаа тайланг танилцуулж байна.

2019 онд Монголын Философийн холбоо нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, нийтэд таниулах, философийн сургалт, сурталчилгааны ажлыг хөхиүлэн дэмжих чиглэлээр ажил зохион байгуулах **зорилт** тавин ажиллаа.

Монголын Философийн Холбоо нь 2019 оны үйл ажиллагааны тайлангаа “Удирдлага, зохион байгуулалт”, “Санхүү”, “Нийгмийн хариуцлага”, “Хамтын ажиллагаа”, “Мэдээлэл, сурталчилгаа” гэсэн дөрвөн чиглэлээр боловсруулав.

### **Удирдлага, зохион байгуулалт**

2019 оны 5-р сарын 23-ны өдөр Холбооны бүх гишүүдийн хурлыг зохион байгуулж, Удирдах зөвлөлийн гишүүд, Ерөнхийлөгчийг сонгосон. Хуралд 10 байгууллагын 40 орчим гишүүн оролцож, Ерөнхийлөгчөөр доктор Д.Гантөмөрийг сонгосон. Бүх гишүүдийн хурлаас холбооны дүрэмд өөрчлөлт оруулах санал гарч, удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт болон Нийслэлийн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст бүртгүүлэв.

## МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБОО



### **Бүх гишүүдийн хурал**


2019 оны 5-р сарын 23-ны 15:00-17:00 цаг  
Соёлын төв өргөөний 3-р давхарт ШУА-ийн хурлын танхим

2019 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж, Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган үйл ажиллагааны чиглэл болгож ажилласан.

Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, төрийн болон ТББ-д ажиллаж буй, философич мэргэжилтэй хүмүүсийн бүртгэлийг нэгтгэж гаргасан.

2019 оны 6-р сарын 28-нд Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлыг зохион байгуулж, ойрын хугацаанд хийх ажлыг хэлэлцсэн.

2019 оны 9-р сарын 27-оос Холбооны <http://mongolianphilosophy.org/> вэб сайтыг ажиллуулж эхлээд байна. Тус вэб сайт нь англи, монгол хэлээр **“Бидний тухай, Удирдах зөвлөлийн гишүүд, Гишүүнчлэл, Мэдээлэл, Шинэ бүтээл, Судалгаа сургалт, Холбоо барих”** гэсэн үндсэн цэсүүдээс бүрдэж байгаа юм. Вэб сайтыг “Суперассист систем” компани хариуцан гүйцэтгэж, үнэ төлбөргүйгээр мэдээллийг шинэчилж байна.



## Санхүү

2020 оны 1-р сарын 26-нд Холбоонд бүртгэлтэй байгаа философийн багш нар, судлаачдад хандан шинэчилсэн анкетыг бөглөж өгөх, татвараа төлөхийг уриалсан.



### **Нийгмийн хариуцлага**

Холбооны нийгмийн хариуцлагын хүрээнд соён гэгээрүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, байгууллагуудын хүсэлтээр лекц унших, эрдэм шинжилгээний хурал удирдах, стратегийн баримт бичгийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах зэрэг ажлыг хийсэн байна. Тухайлбал, М.Золзаяа 7-р сарын 29-нд Хилийн 0218-р ангийн бие бүрэлдэхүүнд **“Хувь хүний хөгжил ба байгууллагын ёс зүй”** сэдвээр лекц уншсан.

Нийслэлийн боловсролын газрын хүсэлтээр Отгонтэнгэр Их Сургуулийн профессор Б.Галиндэв, ХААИС-ийн багш, доктор Г.Уянга нар 10-р сарын 22-ны өдөр Нийслэлийн 20 гаруй ЕБС-ийн багш нарын сургалтанд нийгмийн ухааны хичээлийн философийн бүлгийг заах арга зүйн асуудлаар лекц уншсан байна.

9-р сарын 10-нд Гандантэгчэнлин хийдийн Батцагаан цогчэн дуганы нээлтийн арга хэмжээг тохиолдуулан зохион байгуулсан "Самвад-III" Олон улсын хурлын **“Үнэт зүйл ба Азийн ардчилал”** нэгдүгээр салбар хуралдааны нээлтийн хуралдааныг МФХ-ны ерөнхийлөгч, доктор Д.Гантөмөр Энэтхэгийн судлаачтай хамтран удирдав.



**Номын үзэсгэлэн:** Дэлхийн философийн өдрийг тохиолдуулан 11-р сарын 20-27-нд Монголын Үндэсний Номын санд философийн номын үзэсгэлэн байгуулсан.

Мөн 18-22-нд Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын санд номын үзэсгэлэнг зохион байгууллаа. Энэ үйл ажиллагаа нь анх удаа зохион байгуулагдсанаараа онцлог бөгөөд уншигчдын талархлыг хүлээсэн ажил болсон. Цаашид МҮНС жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусгаж уламжлал болгохоор шийдвэрлэсэн болно.



### **Эрдэм шинжилгээний ажил**

Манай улс дахь философийн сургалт, судалгааны байгууллага амжилт бүтээл арвин жил байв. Эрдэмтэн судлаачид дараах бүтээлүүдийг туурвин нийтийн хүртээл болголоо. Тухайлбал, доктор, профессор Ч.Ган-Өлзий “Тогтвортой хөгжилд чиглэсэн үйлийн ёсны боловсрол”, “Тогтвортой хөгжил: Нийгмийн шударга ёсны философи”, Доктор, профессор Б.Галиндэв “Лев Толстойн ертөнц ба хүний асуудал”, “1990-ээд оноос хойших Монголын философийн амьдрал” хамтын бүтээлүүдийг хэвлүүлжээ.



МФХ-ы Ерөнхийлөгч, доктор Д.Гантөмөр “Аялал жуулчлалын нийгэм-соёлын философийн шинжилгээ” нэгэн сэдэвт бүтээлээ хэвлүүлж, Үндэсний номын баярын өдөр нийтийн хүртээл болгосон юм.

### **Эрдэм шинжилгээний бага хурал:**

Зүүн хүрээ Дашчойлин хийд, Бурханы шашин соёл судлалын хүрээлэн, “Зүүн хүрээ” коллежоос санаачлан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор **“Өндөр гэгээний үсгийн урлал”** эрдэм шинжилгээний бага хурлыг 2019 оны 10-р сарын 4-ний өдөр Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн үзэсгэлэнгийн танхимд амжилттай зохион байгууллаа. Хурлын хамтран **зохион байгуулагчаар** Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхим, Монголын философийн холбоо, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей ажилласан. Хуралд МФХ-ны ерөнхийлөгч, доктор Д.Гантөмөр *“Өндөр гэгээний ахуй ёсны тухай үзэл”*, Удирдах зөвлөлийн гишүүн, доктор Г.Мягмарсүрэн *“Таван богдын зохиол бүтээлийн тухай”* сэдэвт илтгэлүүд хэлэлцүүлжээ.



Холбооны гишүүд Дэлхийн философийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажилд идэвхтэй оролцож, олон нийтэд мэдээлэл хүргэх талаар сайн ажилласан. Тухайлбал, дэд ерөнхийлөгч, доктор Б.Пүрэвсүрэн, дэд ерөнхийлөгч профессор Р.Дарьхүү нар телевиз, өдөр тутмын сонинд ярилцлагууд өгсөн байна.

Дэлхийн философийн өдөрт зориулан 11-р сарын 19-нд Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Философийн Холбоо, МУИС-ийн Философийн салбар төгсөгчдийн холбоо, Номын Гурван Хүрдэн сан зэрэг байгууллага хамтран **“Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгууллаа.

Энэ удаагийн хуралд МУИС, ШУТИС, СУИС, АШУУИС, ХААИС, ШУА-ийн Философийн хүрээлэн, Боловсролын хүрээлэн, Отгонтэнгэр Их Сургууль, Мандах Их Сургууль, Их Засаг Их Сургууль, Ховд Их Сургууль, Завхан аймгийн Элдэв-Очирын нэрэмжит ЕБС, Эрин Эверест Интернэйшнэл сургуулийн эрдэмтэн багш нар, судлаачид илтгэлээ хэлэлцүүлсэн болно. Хурлын илтгэлийн эмхэтгэлийг МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимээс эрхлэн хэвлүүлсэн.

Тус эмхэтгэлд экологийн ёс зүйн боловсрол, байгаль орчныг хамгаалах уламжлал, экологийн ёс зүйн орчин үеийн онол-практикийн асуудлууд зэрэг чиглэлээр их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 45 эрдэмтэн судлаачийн 30 илтгэл багтсан байна. Тухайлбал, профессор Д.Тунгалаг “*Байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт монгол сэтгэлгээний онцлог*”, профессор Б.Галиндэв “*Экологийн боловсрол, ёс зүй эх оронч үзлийн тулгуур болох нь*”, профессор Р.Дарьхүү “*Монгол улс дахь экологийн ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал*”, профессор М.Гантуяа, магистр Б.Бадрах нарын “*Байгаль орчлонгийн талаарх нүүдэлчдийн ба буддын уламжлалт үзэл ойлголтын зохицол*”, доктор Ц.Батцэрэнгийн “*Био ёс зүйн хөгжил ба монгол уламжлал*”, профессор Б.Дагзмаа, доктор Б.Мөнхжавхлан нарын “*Хүрээлэн буй орчны философи*” хичээлийн хөтөлбөр, агуулгын тухайд”, профессор И.Лхам, доктор Г.Уянга нарын “*Хүрээлэн буй хамгаалах үйлсэд их сургуулийн санаачилга, манлайлал*”, доктор Д.Гантөмөрийн “*Аялал жуулчлалын ёс зүй*”, М.Золзаяагийн “*Ногоон ёс зүй хэмээх ойлголтыг тодруулах нь*” зэрэг илтгэлүүд хэвлэгдсэн байна. Эмхэтгэлийг Дэд ерөнхийлөгч, профессор Р.Дарьхүү, Удирдах зөвлөлийн гишүүн дэд профессор Д.Оюунгэрэл, Гүйцэтгэх захирал доктор М.Золзаяа нар хянан тохиолдуулжээ.



Арваннэгдүгээр сарын 21-ний өдөр ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын Философийн Холбоо, ЮНЕСКО-ийн МҮК, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн



музей хамтран “Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.

Хуралд ОУСДС-ийн үүсгэн байгуулагч, профессор Д.Дашпүрэв “Монголын оюун санаа: Монголын түүх бичлэгийн үндсэн үзэл санаа”, СУИС-ийн профессор С.Дулам “Монголчуудын үндэсний ижлсэл-ондоошлын тэмдэг, бэлгэдлийн судалгаа”, ШУТИС-ийн профессор А.Энхбаатар “Монгол дахь философийн хөгжил: индигенизаци”, Монгол Улсын Консерваторийн дэд захирал, доктор Ш.Ариунаа “Аж үйлдвэрийн IV хувьсгалын үед соёл хоорондын харилцаа чухалчлагдах нь”, Отгонтэнгэр Их сургуулийн профессор Б.Галиндэв “Өнөөгийн Монголын нийгмийн оюун санааны орон зайн төлөв байдал, агуулга, чиг хандлага”, С.Одхүү “Монгол менталитетийн асуудал”, доктор Д.Гантөмөр “Монголын оюун санааны тогтвортой хөгжлийн асуудал”, Б.Дэлгэрмаа “Тогтвортой хөгжилд үндэсний соёл чухал болох нь”, докторант Ц.Мөнх-Эрдэнэ “Монголчуудын бичиг соёлын өв уламжлал ба хэрэглээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. ШУА-ийн Философийн хүрээлэнгээс “Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв” эмхэтгэлийг хэвлүүлжээ.

### **Мэдээлэл, сурталчилгаа**

2019 оны 8-р сарын 30-нд хичээлийн шинэ жилд зориулж доктор С.Соёлмаа, Г.Уянга нарын “Их дээд сургуулийн философийн сургалтын өнөөгийн байдал” сэдэвт ярилцлагыг МҮОНТ-ийн сайтад нийтэлсэн.

<http://www.mnb.mn/p/183524>

Холбооны вэб сайтыг “Ярилцлага” булангийн анхны зочноор УЗ-ийн гишүүн, ШУТИС-ийн багш, доктор Ц.Батцэрэнгийн “Философи нь зөв үзэл хандлагатай, хариуцлагатай мэргэжилтэн бэлтгэхэд тусална” ярилцлагыг нийтлүүлсэн.

<http://mongolianphilosophy.org/67.html>

Удирдах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн дэд профессор Д.Оюунгэрэл 11-р сарын 21-нд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор Б.Даш-Ёндонтой “Философи бол ерөнцийг харах зөв цонх мөн” хэмээх ярилцлага хийж, холбооны сайтад нийтэлснийг 900 хүн уншжээ.

[http://mongolianphilosophy.org/list?category\\_id=20](http://mongolianphilosophy.org/list?category_id=20)

Философийн багш, судлаачдын бүтээлийг сурталчлахад анхаарч байна. Энэ хүрээнд 2015 оноос хойш хэвлэгдсэн нийт 14 ном, сурах бичгийн товч мэдээг вэб сайтад байршуулсан.

Дэлхийн философийн өдрийн үйл ажиллагааны талаарх мэдээг МҮОНТ-ийн вэб сайтаар олон нийтэд мэдээлсэн. <http://www.mnb.mn/i/192099>

Мөн Дэлхийн философийн өдрийн үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөрийг гаргаж сошиалаар мэдээлсэн.

ДЭЛХИЙН ФИЛОСОФИЙН ӨДӨР -2019			
АРГА ХЭМЖЭЭ	ХЭЗЭЭ	ХААНА	ЗОХИОН БАЙГУУЛАГЧ
Философийн номын үзэсгэлэн	11.20-24	МҮНС-ийн 3-р давхар	Монголын үндэсний номын сан Монголын философийн холбоо
“Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв” Эрдэм шинжилгээний бага хурал	11.21 10:00-14:00	Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн хурлын танхим	ШУА-ийн Философийн хүрээлэн ЮНЕСКО-ийн МҮК Монголын философийн холбоо ЮНЕСКО-ийн Бээжин дэх төлөөлөгчийн газар Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей
Философи хүний эрхийн уулзварт: Философийн улсын XI олимпиад	11.22 11:00	ХААИС-ийн Төв байр, Хагантуул театр	ХААИС, МУИС Эмнэсти интернэшнл
“Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй” Эрдэм шинжилгээний бага хурал	11.19 09:00-17:00	МУИС-ийн Төв байр, Эрдмийн танхим	МУИС, ШУТИС Монголын философийн холбоо МУИС-ийн Философийн салбар төгсөгчдийн холбоо
Философийн номын үзэсгэлэн	11.18-22	Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан	Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сан Монголын философийн холбоо

Доктор М.Золзаяа залуу судлаачдад зориулан “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах хэдэн зүйл” нийтлэл бичиж вэб сайтад байршуулсан.

Мөн вэб сайтыг дагалдуулан дараах сошиал хаягуудыг хөтөлж байна.

FACEBOOK: [Mongolian Philosophical Association](#)

TWITTER: [Mongolian Philosophical Association](#)

YOUTUBE: [Mongolian Philosophical Association](#)

*Хавсралт 1. Гэрэл зураг*



*ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хурлын танхим. 2019.05.23.*



*ХААИС-ийн Хатан туул театр. 2019.11.22.*



*Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Төвхөн хийдэд Соёмбо үсэгт зориулсан гэрэлт хөшөө-тааллын шүтээн. 2019.10.06*



*Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. ЭШБХ. 2019.11.19.*